



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/51

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Мөнхсайхан овогтой Лхагвасүрэн (РЭ88010611)-ын хүсэлтийг үндэслэн Мөрөн сумын 7 дугаар багт байршилтай 6712014650 нэгж талбарын дугаартай 778м<sup>2</sup>, 6712015577 нэгж талбарын дугаартай 249м<sup>2</sup>, 6712015576 нэгж талбарын дугаартай 642м<sup>2</sup> гэр, орон сууцны зориулалттай 3 нэгж талбаруудын газруудыг нэгтгэж нийт 1669м<sup>2</sup> газрыг үлдсэн 21 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/428 дугаар захирамжийн хавсралтын 1, 2, 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшиж байгаа иргэн М.Лхагвасүрэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотроо эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010247